



WORLD BANK GROUP

**Эрчим хүчний зохицуулалтын
олон улсын туршлага,
хөгжлийн чиг хандлага,
анхаарах асуудлууд**

**ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЗОХИЦУУЛАЛТ-20**

2021-11-17



□ **ГҮЙЦЭТГЭХ ГОЛ ҮҮРЭГ-ЗОРИЛГО** = Төрийн монополь үйлчилгээний (эрчим хүч, ус, тээвэр, харилцаа холбоо) үнэ/тариф, санхүүгийн бүтцийг => техник-арилжааны чанар, хамрах хүрээний тодорхой түвшинд, техник-үйл ажиллагааны хязгаарлалтын дор эдийн засгийн зохицуулалтыг хийдэг.

□ **Хүндрэлтэй асуудал?** Үйлчилгээний хэрэглээний янз бүрийн түвшин дэх үнийг тогтоох зорилгоор *Зардал-Чанар-Үйлчилгээний хамрах хүрээний тоон болон оновчтой харьцааг тогтоохыг шаарддаг.*

□ **Зохицуулалт нь зөвхөн монополь зах зээлийн нөхцөлд л зайлшгүй шаардлагатай:** Зохицуулалт нь монополийн болзошгүй сөрөг үр дагаваруудаас зайлсхийхийн тулд өрсөлдөөний нөхцлийг симуляциар бий болгох ёстой: илүүдэл ашиг/эдийн засгийн рент, үнэ/тарифын гажуудлаас үүдэлтэй илүүдэл алдагдал; үйлдвэрлэлийн хязгаарлалт; үйлчилгээний чанар буурах г.м

ЗОХИЦУУЛАЛТ?



WORLD BANK GROUP

□ *Өрсөлдөөний (төгс) орчныг хэрхэн бий болгох вэ?* Зохицуулалт нь эдийн засгийн үндсэн зорилтуудыг хангахад чиглэгддэг. Үүнд:

□ *Эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдал:* Тариф нь үр ашигт компанид шударга, боломжийн хөрөнгө оруулалтын өгөөжийг багтаасан, эдийн засгийн зардлыг нөхөх боломж олгох, үйлчилгээг санхүүжүүлэх мөнгөн урсгал, хангалттай орлогыг бий болгох ёстой.

□ *Бүтээмжийн үр ашиг:* Үйлчилгээний/ үйлдвэрлэлийн зардлыг цаг хугацааны туршид бууруулах (динамик)

□ *Хуваарилалтын үр ашиг:* Ялгаатай тариф нь үйлчилгээг ямар хэмжээтэй авч буйгаас хамаарч гарах өөр өөр түвшний зардлыг тусгах ёстой (хэрэглэгч, үйлдвэрлэгчдийн хувьд оновчтой цэг)



□ Төрийн үйлчилгээний зохицуулалтыг авч үзэх үед зохицуулалтын үед гарч ирдэг бусад чухал зорилтуудыг хангах шаардлагатай болдог:

- **Нийгмийн зорилтууд:** *Ямар ч хэрэглэгч/айл өрх орлого (байршил эсвэл бусад нөхцөл байдал)-оос шалтгаалан үйлчилгээнд хамрагдахгүй байх ёсгүй - боломжит татаасыг сайтар чиглүүлэх ёстой. (Жишээ нь, өндөр орлоготой хэрэглэгчид татаас шаардлагагүй бөгөөд авах ёсгүй. Харин бага орлоготой хэрэглэгчид шаардлагатай татаасыг авах нь зохистой.)*
- **Энгийн ба санал зөрөлдөөнгүй байх:** *Үнэ/тарифын бүтэц нь бүх хэрэглэгчид ойлгож, хүлээн зөвшөөрөхүйц энгийн байх ёстой.*

Зохицуулалт? Түүхэн замнал



WORLD BANK GROUP

- **Монополийн зохицуулалт? 19 дүгээр зууны төгсгөл үе**
 - *АНУ Муж улс хоорондын Арилжааны Хууль 1887: Төмөр замын зохицуулалт (“үндэслэлтэй, шударга өгөөжийг холбооны зохицуулагч тогтооно” гэсэн заалт бий)*
- **Зохицуулалтын хэлбэр (Зохицуулалтын бодлого /Тогтолцоо) ? 100 жилийн туршид тарифыг тогтооход/ Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг = Үйлчилгээний түүхэн өртөг + Хөрөнгийн өгөөж; Зохицуулалтын энэхүү энгийн тогтолцоо нь асуудал дагуулж байсан:**
 - *Зардлыг бууруулах хөшүүрэг болж чадахгүй байсан. Мөн хөрөнгийн өртөг болон хэмжээг оновчтой хэмжээнд хүргэх хөшүүрэг болж чадахгүй байсан. Учир нь зардал өндөр, хөрөнгийн үнэ өндөр байх тутам автоматаар өндөр өгөөж, илүү их мөнгө олж байсан.*



WORLD BANK GROUP

ЗОХИЦУУЛАЛТ?

1980-1990 оны хувьсгал

□ 1980-аад оны зах зээлийн давалгаа, либералчлал, хувьчлал нь хувьчлагдсан төрийн үйлчилгээг хянах/зохицуулах шинэ арга барил хэрэгтэй болсон;

□ 1983 онд: “Бритиш Телеком”-ын хувьчлалын хүрээнд профессор Литлчайлдын боловсруулсан аргачлал, зөвлөмж томоохон алхам болсон.

=>

- *Бие даасан зохицуулалт*
- *Ирээдүйд чиглэсэн урамшуулалт зохицуулалт:*
- *Одоогийн болон ирээдүйн хэрэглэгчдийн сайн сайхан байдалд анхаарлаа хандуулах (үнэ/үйлчилгээний чанар/нийлүүлэлтийн аюулгүй байдлын хувьд)*
- *Шаардлагатай, боломжтой үед өрсөлдөөнийг дэмжих,*



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ЗОХИЦУУЛАЛТ

□ Гол бэрхшээл сорилтуудын жишээ?

▪ *Хараат бус зохицуулалт*

Энэ нь улс орны орчин нөхцөл, институци болон улс төрийн соёл, хөгжилтэй нягт холбоотой урт хугацааны зорилт юм. Энэ нь одоо ч зорилт хэвээр байгаа.

▪ *Гүйцэтгэлийн урамшуулал бүхий Ирээдүйд чиглэсэн арга (Forward-looking approach):*

▪ Тодорхой арга зүй, үйл явцыг шаарддаг.

▪ Тодорхой өгөгдөл, мэдээлэл шаарддаг. (Оператор компаниудаас эдгээр өгөгдлийг олж авах процесс, арга хэрэгсэл шаардлагатай);

▪ Үйл ажиллагааны болон хөрөнгийн зардлын үр ашгийн талаар тусгай шинжилгээ, үнэлгээ хийх шаардлагатай (мэргэшсэн ур чадвар, арга хэрэгсэл);

▪ Бизнес төлөвлөлтийн хандлага/сэтгэлгээг бүх оролцогч талуудаас шаарддаг.



WORLD BANK GROUP

ЗОХИЦУУЛАЛТ?

Монгол улсын сорилтууд

- **Тарифын аргачлал:** Онолын хувьд аргачлалд тусгагдсан боловч практик хэрэглээг сайжруулах зүйлүүд байсаар байна. Тухайлбал, хөрөнгийн үнэлгээ, зардлын үр ашгийн үнэлгээ г.м (нэмэлт мэдээлэл, дүн шинжилгээ, арга хэрэгсэл шаарддаг)
- Компанийн хэлбэрт шилжсэн эрчим хүчний үйлдвэрүүд хөрөнгө оруулалтын зардлаа өөрсдөө төлөх, хариуцах ёстой. (Энэ нь тариф бүх зардлыг нөхөх үед л боломжтой.)
- Одоогийн түүхэн өртгийн арга (өнгөрсөн зардалд үндэслэсэн тариф)-аас үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулах урамшуулал (шагнал, торгууль) бүхий **Ирээдүйд чиглэсэн арга (ирээдүйн зардалд суурилсан тариф)** шилжих нь = **Монгол дахь зохицуулалтын гол алхам-ирээдүй юм.** – Энэ нь шинэ процессууд, арга хэрэгслийг шаарддаг. Шинэ арга, сэтгэлгээний талаарх ойлголт, зөвшилцлийг бий болгох



WORLD BANK GROUP

БАЯРЛАЛАА

Ричард Шлирф, Макроконсалтинг

Дэлхийн банкны зөвлөх

rschlirf@macroconsulting.net